



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.12 № 03/2118

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зарласан НХААГ/20240102630 дугаартай "Эмнэлгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Хүрээ амаржих газар)" нийлүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд

№	Өмнөх заалт	Өөрчилсөн заалт
1	ТББ-ын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.1 "Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут гэснийг	ТББ-ын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.1 "Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут" гэж
2	ТББ-ын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.2 "Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут" гэснийг	ТББ-ын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.2 "Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут" гэж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгын цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 3 хуудастай.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
Удирдлага
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Даваадорж Батцэцэг
2024.11.12 13:00

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн дугаар албан бичгийн хавсралт

ТОДРУУЛГЫН ХАРИУ

2024 оны 11 дүгээр сарын 12

Улаанбаатар хот

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	№31 Эм хадгалах хөрөгчийн багтаамжийн хэмжээ техникийн тодорхойлолтод тусгагдаагүй байна. Хэдэн литрийн багтаамжтай байх талаар тодруулж өгнө үү.	522*635*1020 хэмжээтэй, 120 л багтаамжтай.
2	№32 Цусны хөрөгчийн багтаамжийн хэмжээ техникийн тодорхойлолтод тусгагдаагүй байгаа тул хэдэн литрийн багтаамжтай байх талаар тодруулж өгнө үү.	600*620*1200 хэмжээтэй, 160 л багтаамжтай.
3	№33 Хөлдөөгчийн багтаамжийн хэмжээ техникийн тодорхойлолтод тусгагдаагүй байгаа тул хэд литрийн багтаамжтай байх талаар тодруулж өгнө үү.	170*85*94 хэмжээтэй, 113 л багтаамжтай.
4	LED гэрлийн технологи дээр суурилж галоген ламп ашигладаггүй байх Тендерийн техникийн шаардлага LED гэрлийн технологи дээр суурилж галоген ламп ашигладаггүй байх гэж заасан байна. Биохимийн анализатор нь хүний биеийн шингэн (цус, шээс, ийлдэс, тархи нугасны шингэн гэх мэт) тодорхой урвалжтай нийлүүлж, үүсэх урвалыг спектрофотометрийн тусламжтайгаар илрүүлдэг бөгөөд анализаторын хэмжилтийн үндсэн зарчим нь бодисын концентраци болон тодорхой долгионы уртад шингээх гэрлийн хэмжээ хоорондын хамаарлыг тодорхойлдог Бейрийн хууль дээр үндэслэн шинжилж, гарсан үр дүнд анализ хийн бөөрний үйл ажиллагаа, элэгний үйл ажиллагаа болон цусан дахь сахар, өөх тос болон электролит, коагуляци зэргийг тодорхойлох анализатор юм. Биохимийн шинжилгээний аппаратын үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч үйлдвэрлэгчид болох Beckman. Hitachi. Roche. Abbott, Jonhson Mindray болон Seamaty зэрэг үйлдвэрлэгчдийн биохимийн анализаторууд нь дээр дурдсан аргаар шинжилгээ хийдэг бөгөөд галоген ламп ашигладаг байна. Roche diagnostic үйлдвэрлэгчийн хувьд дэлхийн зах зээлд танигдсан, лабораторийн салбарт тэргүүлэгч, шинжилгээ хийхэд тавигддаг гол шалгуур үзүүлэлт болох шинжилгээний үр дүн нь олон улсын чанарын хяналтаар баталгаажсан байдгаараа бусад үйлдвэрлэгч нараас ялгарах гол онцлог болдог. Иймд дэлхийд зөвшөөрөгдсөн ХБНГУ улсын Roche Diagnostics үйлдвэрлэгчийн Cobas 311 биохимийн бүрэн автомат анализатор нь спектрофотометрийн аргаар галоген ламп ашиглан шинжилгээ хийдэг бөгөөд тус тендерийн техникийн шаардлагыг дүйцүүлэн хангана гэж ойлгох уу?	Олон улсад LED гэрэл нь орчин үеийн технологи бөгөөд шинжилгээнд нөлөөлөхгүй гэж европ болон азийн зах зээлд хөгжиж байгаа орнууд үздэг. Мөн эдийн засгийн хөшүүрэгт цахилгаан ба зарцуулах, 6 сар тутам солигдох зардал хэрэгслийн зардал бууруулах чухал нөлөөтэй. Техникийн тодорхойлолтод заасан шалгуурын дагуу ирүүлсэн барааг шаардлагад нийцнэ гэж үзнэ.
5	Тендерийн техникийн шаардлагад сорьцын 135 байрлал гэж заасан байна. Энэхүү үзүүлэлтийн хувьд шинжилгээний үр дүн, гүйцэтгэлийн чанарт нөлөөлөхүйц ач холбогдол бага техникийн	Сорьцын байрлал 120 ба түүнээс дээш байгаа

	<p>үзүүлэлт бөгөөд Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв 2, Интермед эмнэлэг, Грандмед эмнэлэг, Мөнгөнгүүр эмнэлэг зэрэг улсын гуравдугаар шатлал, аймаг, дүүргийн нэгдсэн бүх эмнэлгүүдэд 2014 оноос хойш тогтмол ашиглагдаж байгаа дэлхийн брэнд Roche diagnostic үйлдвэрлэгчийн 108 сорьцын багтаамжтай Биохимийн бүрэн автомат анализаторыг санал болгосон тохиолдолд тендерийн шаардлагыг гүйцэтгэлийн чанараараа дүйцүүлэн хангана гэж үнэлэх үү?</p>	<p>тохиолдолд тооцно.</p>
6	<p>Тендерийн техникийн шаардлагад цус, шээс, үрийн шингэн, ийлдэс, ТНШ болон Плеврийн шингэнд шинжилгээ хийдэг байх гэж заасан байна. Биохимийн анализатор нь хүний биеийн шингэн буюу шээс, ийлдэс, тархи нугасны шингэн зэрэг дээжүүдийг тодорхой урвалжтай нийлүүлж, үүсэх урвалыг спектрофотометрийн тусламжтайгаар илрүүлдэг шинжилгээний аппарат бөгөөд дэлхийд тэргүүлэгч үйлдвэрлэгчид болох Beckman, Hitachi, Roche, Abot, Johnson Mindray болон Seamaty Зэрэг үйлдвэрлэгчидийн биохимийн анализаторууд нь дээр дурьдсан сорьцуудад шинжилгээ хийдэг байна. Roche diagnostic үйлдвэрлэгчийн хувьд дэлхийн зах зээлд танигдсан, лабораторийн салбарт тэргүүлэгч, шинжилгээ хийхэд тавигддаг гол шалгуур үзүүлэлт болох шинжилгээний үр дүн нь олон улсын чанарын хяналтаар баталгаажсан байдгаараа бусад үйлдвэрлэгч нараас ялгарах гол онцлог болдог төдийгүй Монгол улсын хэмжээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв 2 гэх мэт улсын II болон III шатлалын эмнэлгүүд, нарийн мэргэшсэн төвүүдийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж 2014 оноос тасралтгүй ажиллаж байна. Иймд хүний биеийн цус, ийлдэс, шээс, тархи нугасны шингэн зэрэг сорьцуудыг шинжилж олон улсын чанараар баталгаажсан, найдвартай шинжилгээний үр дүнг хэрэглэгчид тасралгүй хүргэж буй дэлхийд зөвшөөрөгдсөн ХБНГ улсын Roche Diagnostics үйлдвэрлэгчийн Cobas 311 биохимийн бүрэн автомат анализаторийг тендерт санал болгосон тохиолдолд тендерийн шаардлагыг гүйцэтгэлийн чанараараа дүйцүүлэн хангана гэж үнэлэх үү.</p>	<p>Техникийн тодорхойлолтод заасан шалгуурын дагуу ирүүлсэн барааг шаардлагад нийцнэ гэж үзнэ.</p>
7	<p>Тендерийн техникийн шаардлагад урвалжийн нээлттэй системтэй байх гэж заасан байна. Шинжилгээний анализатор нь урвалжийн нээлттэй системтэй байх нь шинжилгээний хариу найдвартай байдал болон урвалжийн уусмал, оношлуурын хангалтын тасралгүй байдал, аппарат тоног төхөөрөмжийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагаа зэрэгт асуудал үүсэх эрсдэл байдаг төдийгүй цаашлаад эмнэлгийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх сул талууд байдаг байна. Roche diagnostic үйлдвэрлэгчийн хувьд дэлхийн зах зээлд танигдсан, лабораторийн салбарт тэргүүлэгч, шинжилгээ хийхэд тавигддаг гол шалгуур үзүүлэлт болох шинжилгээний үр дүн нь олон улсын чанарын хяналтаар баталгаажсан төдийгүй урвалжийн хаалттай системтэй байдгаараа бусад үйлдвэрлэгч нараас ялгарах гол онцлог болдог төдийгүй Монгол улсын</p>	<p>Техникийн тодорхойлолтод заасан шалгуурын дагуу ирүүлсэн барааг шаардлагад нийцнэ гэж үзнэ.</p>

	<p>хэмжээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв 2 гэх мэт улсын II болон III шатлалын эмнэлгүүд, нарийн мэргэшсэн төвүүдийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж 2014 оноос тасралтгүй урвалж уусмал, оношлуурын тасалдалгүй, аппарат тоног төхөөрөмжийн найдвартай хэвийн үйл ажиллагаагаар хангагдан ажиллаж байна. Иймд урвалжийн хаалттай системтэй олон улсын чанараар баталгаажсан, найдвартай шинжилгээний үр дүнг хэрэглэгчид тасралгүй хүргэж буй дэлхийд зөвшөөрөгдсөн ХБНГ улсын Roche Dianostic үйлдвэрлэгчийн Cobas 311 биохимийн бүрэн автомат анализаторийг тендерт санал болгосон тохиолдолд тендерийн шаардлагыг гүйцэтгэлийн чанараараа дүйцүүлэн хангана гэж үнэлэх үү.</p>	
8	<p>Бараа нийлүүлэлтийн хуваарь Тендерийн баримт бичгийн бараа нийлүүлэлтийн хуваарьт гэрээ байгуулснаас хойш 60 хоног гэж заасан байх бөгөөд тус тендер шалгаруулалтын багц №1 болон 3-д нарийн нийлмэл бүтэц бүхий олон нэр төрлийн тоног төхөөрөмжийг багтаасан байна. Тус тендер шалгаруулалтад санал болгож буй тоног төхөөрөмжүүд нь гадаад улсад шинээр үйлдвэрлэгдэх ба урьд өмнө нь ашиглагдаж байгаагүй, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг агуулсан бөгөөд импортоор ханган нийлүүлэгдэх бараа бүтээгдэхүүний хувьд хамгийн багадаа 45-60 хоногийн хугацаанд үйлдвэрлэгдэж, тухайн улсаас 20-30 хоногт тээвэрлэгдэн эцсийн хэрэглэгчийн гарт хүртлээ нийтдээ дунджаар 70-90 хоног зарцуулагддаг. Нэг багцад олон нэр төрлийн тоног төхөөрөмжүүд байх тохиолдолд үйл ажиллагаа болон зориулалтаасаа хамааран үйлдвэрлэх хугацаа нь харилцан адилгүй тул тендерийн ерөнхий шаардлагад заасан бараа нийлүүлэлтийн хугацаа нь гэрээ байгуулснаас хойш 60 хоног гэснийг бараа нийлүүлэлтийн үед захиалагч талтай тохиролцон сунгаж болох эсэхэд тодруулга хийж өгнө үү.</p>	Захиалагчтай зөвшилцөх боломжтой.